



# ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

ИТГЭМЖЛЭЛ: ИЛҮҮ АЮУЛГҮЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛЬЕ



Шиао Жианхуа,  
Олон улсын  
итгэмжлэлийн

форум (IAF)-ын дарга

2018 оны Дэлхийн итгэмжлэлийн өдөр нь “Итгэмжлэлээр дамжуулж илүү аюулгүй орчинг бүрдүүлье” гэсэн уриатай зохион байгуулагдаж байна. Аюулгүй ажлын байр, аюулгүй бүтээгдэхүүн, аюулгүй тээвэр, аюулгүй хүнс нь бидний нийтээр хүрэх ёстой хүсэл зорилго мөн.

Гэвч статистик тоо баримтаас харахад бидний хүсэл зорилго бодит амьдралаас хол зөрүүтэй байгааг харуулдаг. Энэ зөрүүтэй байдлыг арилгах нь улс орнуудын Засгийн газар, шийдвэр гаргагч, бизнес эрхлэгчдийн шийдэх ёстой амин чухал асуудал бөгөөд иргэдийн ажлын байр, гэр орон, аялал, тээвэр гээд өдөр тутмын амьдралын бүх нөхцөлийг илүү аюулгүй байлагах шаардлагатай байна.

Стандарт, тохирлын үнэлгээ, итгэмжлэл нь нийтээр тогтоож, хүлээн зөвшөөрсэн аюулгүй байдлыг хангах гол арга хэрэгслэл юм. Энэ арга хэрэгслийг ашиглаж байгаа Дубай дахь итгэмжлэгдсэн гэрчилгээ бүхий аврагчид, Их Британи дахь азбестийн сорилтын итгэмжлэгдсэн лаборатори, Шинэ Зеланд дахь баталгаажуулалтын гэрчилгээ бүхий адал явдалт аяллын үйлчилгээ, Бүгд найрамдах Чех улсын итгэмжлэлийн гэрчилгээ бүхий цахилгааны тоноглол дээр ажилласад, Нидерланд дахь нийтийн орон сууцны лифтний итгэмжлэгдсэн хяналт гэх мэт олон жишээг дурьдаж болно.

Италийн даатгалын компанийн тохирлын үнэлгээ хэрэгжүүлсэн жишээ нь хамгийн цохон тэмдэглүүштэй үр өгөөжөө өгсөн тохиолдол юм. OHSAS 18001, Эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандарт хэрэгжүүлдэг байгууллагын ажлын байран дахь ослын давтамжийг тус стандартыг хэрэгжүүлдэггүй



Мэрих Малмквиист  
Нилссон,  
Олон улсын лаборатори  
итгэмжлэлийн хамтын  
ажиллагааны байгууллага  
(ILAC)-ын дарга



байгууллагын тоо хэмжээтй харьцуулан дүн шинжилгээ хийснээр даатгалын байгууллагаас тус итгэмжлэгдсэн байгууллагад ажлын байрны эрсдэл харьцангуй бага гэж үнэлэн, маш бага даатгалын хураамж төлөхийг санал болгосон байдаг.

Эрүүл мэнд, аюулгүй байдалд учрах эрсдлийг бууруулах менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхэд 2018 оны 3 дугаар сард Олон Улсын Стандартын байгууллагаас анх хэвлэгдсэн Эрүүл мэнд, аюулгүй байдлын тогтолцоо ISO 45001 стандарт асар их тулхэц нөлөөлөл үзүүлэх юм. Уг стандарт нь байгууллагын эрсдлийг нарийн тодорхойлсноор байгууллагын зорилт, бодлого, үйл явц, хяналтаар дамжуулан үйл ажиллагааны эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулна.

Мөн Нидерландын эрүүгийн системд ДНХ-ийн нотлох баримтыг ашиглахдаа ДНХ-ийн шинжилгээ хийсэн лабораторийг ISO/IEC 17025 стандартын дагуу итгэмжлэгдсэн байх шаардлага тавьдаг. ДНХ-ийн шинжилгээ хийдэг лаборатори нь Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (ILAC)-ын Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (MRA)-т нэгдсэн итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлэгдсэнээр шүүхийн системийг илүү итгэлтий болгож, иргэдийн аюулгүй байдлыг хангахад тусалж байна.

Дээрх жишээ нь итгэмжлэл, тохирлын үнэлгээгээр дамжуулан илүү аюулгүй орчинг бүрдүүлэх үр өгөөжийн талаарх маш олон жишээний нэгзэхэн хэсэг юм. Хэрэгжсэн төслийд, түүхий эд, бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээ, менежментийн тогтолцоо, ажилтан нь стандарт, код болон зохицуулалтын шаардлагын дагуу сорилт, шалгалт тохирууллын лаборатори, техникийн хяналтын байгууллага, баталгаажуулалтын байгууллага, магадлагага ба нотолгооны байгууллагаар хянагдаж, тохирлын үнэлгээ хийгддэг билээ. Тохирлын

үнэлгээний байгууллага нь бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэхэд аюулгүй байдлыг хангаж байгаа эсхийг шалгадаг.

Итгэмжлэл нь тохирлын үнэлгээний байгууллагын хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу явуулж буй үйл ажиллагааны нэгдмэл, бие даасан байдал болон чадавхийг хөндлөнгөөс үнэлэх ажиллагаа юм.

Үндэсний болон олон улсын стандарттаар дамжуулан төр, хувийн хэвшлийн байгууллага болон нийгэм, олон нийт шалгалт тохируулга, сорилтын үр дүн, хяналтын тайлан, баталгаажуулалтын гэрчилгээнд итгэх итгэл үнэмшигийг олж авч, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

2018 оны Дэлхийн итгэмжлэлийн өдөр нь бизнес эрхлэгч, төр засгийн байгууллага, шийдвэр гаргагчдад стандарт, тохирлын үнэлгээ, итгэмжлэлээр дамжуулан аюулгүй орчинг бүрдүүлэх таатай нөхцөл боломжийг олгож байна. Итгэмжлэлээр дамжуулан аюулгүй орчинг бүрдүүлэх талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл бүхий зурагт хуудсыг IAF, ILAC-ийн цахим худаснаас татаж авах боломжтой.

Дэлхийн Итгэмжлэлийн өдрийг тохиолдуулан дэлхийн 100 гаруй улс оронд аюулгүй орчинг бий болгоход итгэмжлэлийн үзүүлэх нелөө, ач холбогдлыг сурталчлах зорилгоор томоохон арга хэмжээ, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, хурал, семинар чуулж байна.

Өөрийн орныхоо Итгэмжлэлийн асуудал хариуцсан байгууллагын илүү дэлгэрэнгүй мэдээллийг Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллагын Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрт гарын үсг зурсан талуудын жагсаалтаас <http://ilac.org/signatory-search/> болон Олон улсын итгэмжлэлийн форумын жагсаалтаас [http://www.iaf.nu//articles/IAF\\_MEMBERS\\_SIGNATORIES/4](http://www.iaf.nu//articles/IAF_MEMBERS_SIGNATORIES/4) харна уу.

